

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арцсуурь дахь гаалийн хорооны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2022/205/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүргийг түр

орлон гүйцэтгэгч : Г.Заяа

Утас:92038288

Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Интер аудит ХХК

Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг

Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: altan_fin@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.6.1 Төсвийн төлөвлөлт	13
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.6.3 Нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	14
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит	14
4.2.1 Залруулсан алдаа.....	14
4.2.2 Төлбөрийн акт.....	14
4.2.3 Албан шаардлага	14
4.2.4 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
СХОГ	Санхүү, хөрөнгө оруулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12

_____ № _____
_____ танай _____-ны № _____-т

АРЦСУУРЬ ДАХЬ ГААЛИЙН
ХОРООНЫ ДАРГА Р.ЦЭРЭНДОРЖ-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арцсуурь дахь гаалийн хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Арцсуурь дахь гаалийн хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

11.8 сая төгрөгийн анхан шатны баримтын зөрчилтэй ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, 4.6 сая төгрөгийн шатахууны зарцуулалтад жолоочийн тооцоо бодоогүй, хөрөнгийн тооллогын үр дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчил нь (Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 13.7, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй) байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

013822070

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>26,625,102.83</u>	<u>41,248,985.36</u>
33	АВЛАГА	9,662,441.06	9,662,441.06
335	Бусад авлага	9,662,441.06	9,662,441.06
3351	Байгууллагаас авах авлага	9,662,441.06	9,662,441.06
35	БАРАА МАТЕРИАЛ	16,962,661.77	31,586,544.30
35300	Бэлэн бүтээгдэхүүн	45,000.00	-
354	Хангамжийн материал	16,917,661.77	31,586,544.30
35410	Бичиг хэргийн материал	1,185,764.00	1,730,417.30
35420	Аж ахуйн материал	9,581,618.00	21,850,468.00
35440	Түлш, шатах тослох материал	5,734,978.77	7,720,360.00
35470	Бусад хангамжийн материал	415,301.00	285,299.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>553,920,306.81</u>	<u>506,478,286.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	553,920,306.81	506,478,286.13
392	Биет хөрөнгө	506,879,913.81	459,503,893.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	352,082,616.77	352,082,616.77
39202	Хуримтлагдсан элэгдэл	(61,346,041.92)	(92,019,062.88)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,600,000.00	73,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,600,000.00)	(73,600,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	371,254,669.90	371,927,969.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	(155,111,330.94)	(176,987,630.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,224,032.00	7,724,032.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,224,032.00)	(3,224,032.00)
393	Биет бус хөрөнгө	47,040,393.00	46,974,393.00
39301	Програм хангамж	31,624,393.00	31,624,393.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(738,000.00)	(804,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,154,000.00	16,154,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>580,545,409.64</u>	<u>547,727,271.49</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>(26,548,418.81)</u>	<u>547,727,271.49</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	(26,548,418.81)	547,727,271.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	607,093,828.45	607,093,828.45
512	Хуримтлагдсан үр дүн	(197,694,257.31)	(230,512,395.46)
51210	Өмнөх үеийн үр дүн	(340,947,067.15)	(197,694,257.31)
51220	Тайлант үеийн үр дүн	143,252,809.84	(32,818,138.15)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	171,145,838.50	171,145,838.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>(26,548,418.81)</u>	<u>547,727,271.49</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	260,520,200.00	261,313,510.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	972,000.00	1,106,110.00
120	Нийтлэг татварын бус орлого	972,000.00	1,106,110.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,106,110.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,106,110.00
120009	Бусад орлого	972,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	259,548,200.00	260,207,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	259,548,200.00	260,207,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	259,548,200.00	260,207,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	277,398,270.16	294,112,398.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	277,398,270.16	294,112,398.15
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	266,451,955.49	274,134,730.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,358,232.53	171,513,471.68
210101	Үндсэн цалин	146,176,734.29	149,574,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,215,000.00	9,940,000.00
210104	Урамшуулал	11,966,498.24	11,998,771.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,890,902.52	23,175,879.05
210201	Тэтгэврийн даатгал	13,525,813.44	16,293,779.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,273,017.66	1,372,107.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,591,272.51	1,715,134.97
210204	Ажилгүйдлийн даатгал	318,254.50	364,587.12
210205	Эрүүл мэндийн даатгал	3,182,544.41	3,430,269.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,252,396.51	13,748,895.66
210301	Гэрэл, цахилгаан	4,706,494.28	4,034,276.89
210302	Түлш, халаалт	14,545,902.23	9,714,618.77
2104	Хангамж, бараа материалын зардал	7,305,219.00	6,097,018.70
210401	Бичиг хэрэг	1,877,970.00	784,356.70
210402	Тээвэр, шатахуун	4,666,519.00	4,649,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	373,430.00	140,360.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	142,000.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	245,300.00	423,002.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,816,600.00	2,717,550.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	118,000.00	700,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,698,600.00	207,550.00
210604	Урсгал засвар		1,810,000.00
2107	Томилот, зочны зардал	810,100.00	1,200,000.00
210702	Дотоод албан томилот	810,100.00	1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,343,570.00	1,086,595.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,100,000.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	135,000.00	540,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,120.00	54,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		388,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,674,934.93	54,595,320.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		1,980,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	47,674,934.93	52,615,320.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,946,314.67	19,977,667.38
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,946,314.67	19,977,667.38
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	10,946,314.67	19,977,667.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(16,878,070.16)	(32,798,888.15)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	19,250.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		19,250.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(19,250.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(16,878,070.16)	(32,818,138.15)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,093,828.45	171,145,838.50	(340,947,067.15)	437,292,599.80
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	607,093,828.45	171,145,838.50	(340,947,067.15)	437,292,599.80
C07	Тайлант үеийн үр дүн			143,252,809.84	143,252,809.84
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,093,828.45	171,145,838.50	(197,694,257.31)	580,545,409.64
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,093,828.45	171,145,838.50	(54,441,447.47)	580,545,409.64
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	607,093,828.45	171,145,838.50	(197,694,257.31)	580,545,409.64
D08	Тайлант үеийн үр дүн			(32,818,138.15)	(32,818,138.15)
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	607,093,828.45	171,145,838.50	(230,512,395.46)	547,727,271.49

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>260,520,200.00</u>	<u>260,207,400.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	972,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	972,000.00	-
120005	Түрээсийн орлого	972,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	259,548,200.00	260,207,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	259,548,200.00	260,207,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	259,548,200.00	260,207,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>231,460,200.00</u>	<u>255,034,100.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	231,460,200.00	255,034,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	220,513,885.33	235,056,432.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,358,232.53	171,513,471.68
210101	Үндсэн цалин	94,088,220.59	99,563,067.04
210102	Нэмэгдэл	52,855,011.94	50,021,632.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,215,000.00	9,940,000.00
210104	Урамшуулал	11,200,000.00	11,988,771.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,890,902.52	23,175,879.05
210201	Тэтгэврийн даатгал	13,525,813.44	16,293,779.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,273,017.66	1,244,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,591,272.51	2,217,199.34
210204	Ажилгүйдлийн даатгал	318,254.50	311,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,182,544.41	3,109,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,113,950.28	15,876,776.89
210301	Гэрэл, цахилгаан	7,613,950.28	4,376,776.89
210302	Түлш, халаалт	11,500,000.00	11,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,705,930.00	7,889,310.00
210401	Бичиг хэрэг	2,072,400.00	1,345,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,649,300.00	4,649,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	373,430.00	140,360.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	55,500.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	555,300.00	1,654,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,933,300.00	12,334,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,521,700.00	350,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,411,600.00	10,174,400.00
210604	Урсгал засвар	-	1,810,000.00
2107	Томилолт, зочны зардал	810,100.00	1,200,000.00
210702	Дотоод албан томилолт	810,100.00	1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,701,470.00	1,086,595.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,100,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	135,000.00	540,000.00

210803	Даатгалын үйлчилгээ	54,450.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,120.00	54,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	357,900.00	388,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,980,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,980,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,946,314.67	19,977,667.38
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,946,314.67	19,977,667.38
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	10,946,314.67	19,977,667.38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>29,060,000.00</u>	<u>5,173,300.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	29,060,000.00	5,173,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,060,000.00	5,173,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,060,000.00	5,173,300.00
222001	Тоног төхөөрөмж	29,060,000.00	673,300.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		4,500,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(29,060,000.00)</u>	<u>(5,173,300.00)</u>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө /мянган төгрөг/	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	261,247.40	240,229,732.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	261,247.40	239,556,432.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	261,247.40	239,556,432.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,495.30	171,513,471.68
210101	Үндсэн цалин	110,285.60	99,563,067.04
210102	Нэмэгдэл	48,034.80	50,021,632.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,174.90	9,940,000.00
210104	Урамшуулал	12,000.00	11,988,771.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,399.40	23,175,879.05
210201	Тэтгэврийн даатгал	17,624.60	16,293,779.71
210202	Тэтгэмжийн даатгал	1,244.00	1,244,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,109.90	2,217,199.34
210204	Ажилгүйдлийн даатгал	311.00	311,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,109.90	3,109,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,200.00	15,876,776.89
210301	Гэрэл, цахилгаан	7,700.00	4,376,776.89

Арцсуурь дахь гаалийн хорооны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	11,500.00	11,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,325.10	7,889,310.00
210401	Бичиг хэрэг	2,072.40	1,345,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,649.30	4,649,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	703.40	140,360.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800.00	1,654,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,148.00	16,834,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	648.00	350,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,500.00	10,174,400.00
210604	Урсгал засвар	10,000.00	6,310,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,200.00	1,200,000.00
210702	Дотоод албан томилолт	1,200.00	1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,479.60	1,086,595.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	150.00	81,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69.20	54,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	89.40	-
210807	Газрын төлбөр	175.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	396.00	388,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.00	1,980,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.00	1,980,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	673,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	673,300.00
222001	Тоног төхөөрөмж	-	673,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	261,247.40	260,207,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	260,207.40	260,207,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	260,207.40	260,207,400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,040.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,040.00	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Арцсуурь дахь гаалийн хорооны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Арцсуурь дахь гаалийн хорооны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 09-ны өдрийн №06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Арцсуурь дахь гаалийн хороо нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд оршино. Гаалийн байгууллагын гадаад харилцаа, хамтын ажиллагааг гаалийн бодлого, тэргүүлэх чиглэл, стратегитай уялдуулан хөгжүүлж, өргөжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудиторын тайлант оны ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар танилцан хангалтгүй гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Арцсуурь дахь гаалийн хорооны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 260,207.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 3,903.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,927.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	9,662.44	9,662.44	-
Бараа материал	16,962.66	31,586.54	14,623.88
Үндсэн хөрөнгө	553,920.31	506,478.29	(47,442.02)
Нийт хөрөнгө	580,545.41	547,727.27	(32,818.14)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	580,545.41	547,727.27	(32,818.14)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	580,545.41	547,727.27	(32,818.14)

Бараа материалын дансны үлдэгдэл 14,623.88 мянган төгрөгөөр өссөн нь 29,389.4 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл болон түлш тослох материал худалдан авч, дээд байгууллагаас 1,106.1 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүй өгч, 19.2 мянган төгрөгийн мэдүүлгийн маягтыг үнэ төлбөргүй татан авсан, 15,852.4 мянган бараа материал зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 47,442.02 мянган төгрөгөөр буурсан нь 5,173.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, 52,615.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал гарсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 32,818.14 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөр 260,207.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоор 1,040.0 мянган төгрөг, нийт 261,247.40 мянган төгрөгөөр санхүүжихээр тооцон төлөвлөж, урсгал зардлыг 261,247.40 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 260,207.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 240,229.7 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 19,977.7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Нэмэлт санхүүжилт байхгүй.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Жилийн эцсийн тооллогын бүртгэлийн дүнг тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодсон акт үйлддэггүй

3.8 Аудитын гол асуудал

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих нийт 147 мэдээ байршуулахаас 4 мэдээ хугацаа хоцроож хөрөнгө оруулалт худалдан авалттай холбоотой 5 саяас дээш үнийн мэдээтэй мэдээллийг буруу мэдээлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн ба нэгдсэн бодлогын баримт бичигт тусгуулах саналыг ГЕГ-ын СХОГазарт хүргүүлж ажилласан.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ЭДГС компаниас авах авлагыг шийдвэргүйгээр хасалт хийж өмнөх үр дүнд бичилт хийснийг аудитын явцад залруулсан. Уг авлагын шийдвэрлэлтийг хууль эрхийн дагуу хийгдэж байгааг шалгах

4. Аудитын илрүүлэлт

4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Засварын үеийн аудитад хамрагдаагүй байна.

4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 25,703.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 9,662.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,037.6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14,003.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн байдлын тайланд 9,662.4 мянган төгрөгийн залруулга хийгдсэн. Үүнд:

1.1. Илрүүлэлт:

- ✓ ЭДГС компаниас авах 9,662.4 мянган төгрөгийн авлагыг шийдвэргүйгээр өмнөх үеийн үр дүнд бичилт хийж хаасан байна.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ УСНББОУС15 Топилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдээдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулга хийлгэсэн.

4.2.2 Төлбөрийн акт

1.1. Илрүүлэлт:

- ✓ Иргэн Пүрэвдоржоос худалдан авсан модны үнийг 963.6 мянган төгрөгөөр илүү төлсөн.
- ✓ Ажилтанд 1,074.0 мянган төгрөгийн томилолтын мөнгө анхан шатны баримтгүй олгосон.

1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.5 заалтыг үндэслэн илүү олгосон мөнгийг төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй

4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

- ✓ 4,139.0 мянган төгрөгийн шатахууны тооцоо жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодсон актгүй байна;
- ✓ 9,864.0 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримт /и-баримт/-ыг бүрэн бүрдүүлээгүй;

1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Жолоочийн тооцоог хянах ажлыг сайжруулах, тооцоо бодож хэвших
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Арцсуурь дахь гаалийн хороо	5	25.7	1	9.7	2	2.0			2	14
	Дүн	5	25.7	1	9.7	2	2.0			2	14